


Малын тооны өөрчлөлт: Адуун сүрэг


2021 оны байдлаар мал аж ахуйн салбар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 11.6 хувийг бүрдүүлж, 7.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна [1]. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн нөөцүүдийн нэг болох мал сүргийн тоо толгой, байршил, нягтшил түүнд гарч буй өөрчлөлтийн талаарх товч мэдээллийг малын төрөл тус бүрээр цувраалаар бэлтгэн хүргэж байна.

Монголчууд олон мянган жилийн тэртээгээс таван хошуу малын дотроос адууг эрхэмлэн ирсэн бөгөөд монгол морь нь нүүдэлчдийн ахуй амьдралд чухал үүрэг гүйцэтгэсээр өнөөг хүрсэн [2]. Дэлхий дээр 250 гаруй үүлдрийн адуу байдаг ба Монгол үүлдрийн адууг 13-14 мянган жилийн өмнө төв Азид анх гаршуулжээ [3]. Монгол адуу эх газрын эрс тэс уур амьсгалд зохицсон, тэсвэр хатуужилтай, өвөл хаврын хатуу ширүүн улиралд алдсан тарга хүчээ зун намрын улиралд бүрэн нөхдөг, алс холын болон урт хугацааны уналга эдлэгээг дааж чаддаг мал юм [4]. Монгол адууны биеийн галбир, генетикийн зарим онцлогт нь үндэслэн халх, тэс, мянгад, дархад, галшар гэсэн өмөгт хуваадаг. Хэнтий аймагт галшар омгийн адуу, Завхан, Увс аймагт тэс омгийн адуу, Хөвсгөл аймагт дархад омгийн адуу, Ховд аймагт мянгад омгийн адуу байдаг [5].

1970 оны статистик мэдээг 2021 оны статистик мэдээтэй харьцуулахад адуун сүргийн тоо толгой өссөн ч энэхүү өөрчлөлт нь хугацааны туршид хэлбэлзэж иржээ. Өөрөөр хэлбэл адууны тоо зарим жилүүдэд өсөж, зарим жилүүдэд буурч байжээ. Манай улсын мал сүргийн тоо толгой, сүргийн бүтэц төвшлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед харьцангуй тогтвортой байсан бол зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс малын тоо толгой өсөж, сүргийн бүтэц өөрчлөлт гарсан [6]. Шугаман регрессийн загвараар (95 хувийн статистик үнэмшилтэй) адуун сүргийн тоо толгойн өөрчлөлтийн хандлагыг улсын хэмжээнд тооцоолоход 1970-1989 оны хугацаанд буурах (-13.6 мянган толгой/жил, $r^2=0.46$), 1990-2021 оны хугацаанд өсөх хандлага (47.6 мянган толгой/жил, $r^2=0.36$) ажиглагдсан (Зураг 1). Адуун сүргийн тоо 1970 онд 2.3 сая, 1980 онд 1.98 сая байсан бол 2021 онд 4.3 сая болж суурь оны дүнгээс (1970 оны) 2 дахин өсжээ. Нийт мал сүрэгт адуун сүргийн эзлэх хувь 1970 онд 10.2%, 1980 онд 8.35%, 1990 онд 8.75%, 2000 онд 8.8%, 2010 онд 5.87%, 2021 онд 6.42% болсон. Манай орон зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш адуун сүргийн тоо толгойд гарсан өөрчлөлтийг аймгийн түвшинд авч үзвэл Орхон, Өвөрхангай, Булган, Архангай, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ, Дорноговь, Дархан Уул, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт статистикийн ач холбогдолтой ($p < 0.05$) өсжээ (Зураг 2). Сумын түвшинд авч үзвэл дээрх хугацаанд нийт сумдын 83% буюу 274 суманд адууны тоо толгой өсөх хандлага, 56 суманд буурах хандлага ажиглагдсан (Зураг 3). Улсын хэмжээнд адуун сүргийн тоогоороо Төв, Архангай, Хөвсгөл, Сүхбаатар аймгууд сүүлийн 30 жилийн хугацаанд тэргүүлсээр ирсэн (Зураг 4). 1990 оноос 2021 он хүртэл адуун сүргийн нягтшилд гарсан өөрчлөлтийг Зураг 5-д үзүүлээ. Манай улсын 100 га газар нутагт ногдох адууны тоо 1990 онд дундажаар 1.44 байсан бол 1995 онд 1.71, 2000 онд 1.7, 2005 онд 1.29, 2010 онд 1.22, 2015 онд 2.10, 2021 онд 2.76 болжээ.




Зураг 1. Адуун сүргийн тооны өөрчлөлт (а) 1970 - 1990 он (б) 1990 - 2021 он (в) 1970 - 2021 он



Зураг 4. Аймгуудын адууны тоо ба тухайн онд адууны тоогоор тэргүүлсэн 5 аймгийн адууны улсын нийт адууны тоонд эзлэх хувь


Зураг 2. Аймгуудын адуун сүргийн тооны өөрчлөлт



Зураг 3. Адуун сүргийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага (1990 - 2021 он)

Ашигласан материал

- Үндэсний статистикийн хороо. (2022). Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2021. Улаанбаатар, Монгол. https://www2.1212.mn/BookLibraryDownload.aspx?url=Agriculture_2021.pdf&ln=Mn
- Төмөржав, М., Энхтүвшин, Б., Санпидэндэл, Х., Эрдэнэцогт, Н., Очир, А., Цэвээндорж, Д., Эрдэнэболд, Л., Байрацан, Батархүү, Цэрэндорж, Баясгалан, Т. (2008) “Нүүдлийн мал аж ахуйн түүх” сэдэвт төслийн эрдэм шинжилгээний тайлан. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хурээг, Улаанбаатар, Монгол. <http://www.data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=105315>
- Самданжамц, Д., Алтангэрэл, Д., Сайнолда, Т., Цэвээн, Ц., Бямбацогт, Я., Цэнд-Аюуш, М. (2004). “Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох” сэдэвт төслийн эрдэм шинжилгээний тайлан. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хурээг, Улаанбаатар, Монгол. <http://www.data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=107643>
- Самданжамц, Д., Сайнолда, Т., Цэнд-Аюуш, М., Цэвээн, Ц., Бейсен, Б., Бямбацогт, Я. (2007). “Хурдан удмын адууны цөм сүрэг бий болгох” сэдэвт төслийн эрдэм шинжилгээний тайлан. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хурээг, Улаанбаатар, Монгол. <http://www.data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=107509>
- Жанчив, Ц., Түмэнсэмаа, Х., Цэндсүрэн, Ц., Мөнхтуяа, Б., Туяа, Ц., Цэндсэмаа, Л., Оюунгэрэл, С. (1998). “Бэлчээрийн Монгол малын генетик ресурс, түүнийг ашиглах арга зам” сэдэвт төслийн эрдэм шинжилгээний тайлан. Биологийн хурээг, Улаанбаатар, Монгол. <http://www.data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=108238>
- Бакей, А., Намбат, Л., Пүрэв, Б., Ундармаа, Ж., Сайнолда, Т., Калирбек, Д. (2013). Бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн нийгэм-эдийн засаг, экологийн хүчин зүйлсийн судалгаа. Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Улаанбаатар, Монгол. <http://data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=105858>
- Үндэсний статистикийн хороо. Малын тоо. Улаанбаатар, Монгол. https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1001_021V1



Зураг 5. Адуун сүргийн нягтшилд гарсан өөрчлөлт (1990 - 2021 он)